

# Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга судалгаа

# 2019



Өмнөговь аймаг  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## Агуулга

ОРШИЛ.....	2
ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ.....	3
НЭГ. Малчдын тоо тэдний соёл ахуйн үзүүлэлт.....	6
I.1 Малчдын тоо, насны бүтэц.....	6
I.1.2 Малчдын соёл ахуйн үзүүлэлт.....	7
ХОЁР. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн.....	8
II.1. Малын тоо бүтэц.....	8
II.2 Хувийн /амины/ малын тоо бүтэц.....	13
II.3 Малтай өрхийн малын бүлэглэлт.....	13
II.4. Хээлтэгч мал.....	14
II.5 Төл бойжилт.....	16
II.6 Том малын зүй бусын хорогдол.....	16
II.7 Малын хээл хаялт, сувайралт.....	17
II.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	19
II.9 Малын хэрэглээний зарлага.....	20
II.10 Сүргийн бүтэц.....	20
ГУРАВ. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	
III.1 Бэлчээрийн хүрэлцээ.....	22
III.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт.....	23
III.3 Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж.....	24
ДҮГНЭЛТ.....	25

## Оршил

Өмнөговь аймгийн эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар өнөөг хүртэл тэргүүлэх байр суурийг эзэлсээр ирсэн бөгөөд цаашид ч мөн уул уурхайн салбарыг даган эрчимтэй хөгжүүлэх бодлого чиглэлийг баримталж байна.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээл, худаг усны тооллогыг 2019 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж явууллаа.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

**Судалгааны зорилго:** Аймгийн эдийн засагт Хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь, цаашдын хандлагыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

**Судалгааны агуулга:** Энэ зорилгоор мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжил, малчдын амжиргааны талаар бодлого, малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт, хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүдийг тодорхойлох, газар тариалангийн салбарын хувьд тариалалт, ургац хураалт, ургацын хэмжээг тооцов.

## НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

**Малтай өрх:** Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

**Малчин өрх:** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх.

**Малчид:** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

### Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	- 1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

### Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	- 5 хонь
1 адуу	- 7 хонь
1 үхэр	- 6 хонь
1 хонь	- 1 хонь
1 ямаа	- 0.9 хонь

Бог-д шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

**Нас гүйцсэн мал:** Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

### Өсвөр насны мал:

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу- Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

**Төл мал:** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч:** Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

**Малын тоо, толгойн өсөлт:** Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

**Төллөлтийн хувь:** Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

**Бойжилтын хувь:** Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

**100 эхээс бойжуулсан төл:** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо:** Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25
Азарга -	12-15
Бух -	35-45
Хуц, ухна -	25-30

**Том малын зүй бус хорогдолд:** Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

**Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь:** Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

**Малын хэрэглээний зарлага:** Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

**Малын хашааны хангамж:** Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

**Тэжээл хангамж:** Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

**Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент:** Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс	-	0.45
Таримал тэжээл	-	0.35
Даршны ургамал	-	0.25
Гар тэжээл, хужир шүү	-	1.00
Төмс ногооны хаягдал	-	0.22
Үр тарианы хаягдал	-	0.90
Лай	-	0.40
Сүрэл	-	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

**Малын тэжээлийн ангилал:** Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.  
Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.  
Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.  
Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

**Тариалангийн талбай:** Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

**Тариалсан талбай:** Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Хураасан талбай:** Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Га-гийн ургац:** Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

**Нийт ургац:** Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

## 1. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН БАЙДАЛ

## 1.1. Малчдын тоо, насны бүтэц:

хүснэгт 1

## Өрх, малчдын тоо насны бүтэц

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
											хувь	зөрүү
Малтай өрх	6894	6661	6619	6713	6771	6963	7172	7418	7496	7707	102.8	211
Малчин өрх	5628	5431	5131	5173	5216	5417	5647	5819	5951	6108	102.6	157
Малчдын тоо	10258	9751	9279	9226	9449	9588	9846	9635	9593	9671	100.8	78
Үүнээс: 16-34 насны	4640	4154	3695	3534	3493	3473	3408	3084	3012	2898	96.22	-114
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	4388	4366	4544	4706	4944	5135	5353	5079	5151	5290	102.7	139
Тэтгэврийн насны	1230	1231	1040	986	1012	980	1085	1431	1430	1483	103.7	53
Нийт малчдаас эмэгтэй	4809	4598	4403	4382	4408	4378	4503	4315	4269	4237	99.25	-32
Насны бүрэлдэхүүн %	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	0
Үүнээс: 16-34 насны	45.2	42.6	39.8	38.3	37	36.2	34.6	32.01	31.4	30.0	95.43	-1
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	42.8	44.8	49	51	52.3	53.6	54.4	52.71	53.7	54.7	101.9	1
Тэтгэврийн насны	12	12.6	11.2	10.7	10.7	10.2	11	14.85	14.9	15.3	102.9	0
Нийт малчдаас эмэгтэй %	46.9	47.2	47.5	47.5	46.7	45.7	45.7	44.78	44.5	43.8	98.45	-1
Нэг малчин өрхөд ногдох	180	225	276	320	354	379	409	456	436	491	112.6	55
малын тоо /толгойгоор/												

Эх сурвалж: 2010-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2019 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7707 малтай өрх, үүнээс 6108 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 36.5 хувийг малтай өрх эзэлж байна.

2019 онд мал аж ахуйн салбарт 9671 малчид ажиллаж байна. Нийт малчдын 43.8 хувь нь буюу 4237 эмэгтэйчүүд байна.


Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 2.6 хувиар буюу 157 өрхөөр, малчдын тоо өмнөх оноос 0.8 хувиар буюу 78 малчнаар өссөн үзүүлэлт харагдаж байна.

Нийт малчин өрхийн 30.0 хувийг 16-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд, 54.7 хувийг 35-аас 59 насны хүмүүс харин үлдсэн 15.3 хувийг тэтгэврийн өндөр настай хүмүүс эзэлж байна. Өмнөх онуудтай харьцуулахад 16-34 насны залуучууд мал аж ахуй эрхлэх нь буурч, 35-59 насны хүмүүс, тэтгэврийн насны хүмүүс мал аж ахуй эрхлэх нь ихэссэн үзүүлэлт харагдаж байна.

2019 онд нэг малчин өрхөд 491 толгой мал оногдож байгаа нь өмнөх оноос 55 толгой малаар өссөн байна.

**МАЛЧДЫН ТОО НАСНЫ БҮТЭЦ**

■ 2015 ■ 2016 ■ 2017 ■ 2018 ■ 2019

**1.2. Малчдын соёл ахуйн үзүүлэлт .**

2019 оны мал тооллогын дүнгээр нийт малчин өрхийн 83.7 хувь буюу 5115 өрх цахилгааны эх үүсвэртэй, 77.8 хувь буюу 4754 өрх телевизортой, 57.6 хувь буюу 3521 өрх автомашинтай, 56.4 хувь буюу 3442 өрх мотоциклтой, 0.5 хувь буюу 28 өрх трактортой байна.

Өмнөх онтой харьцуулахад цахилгааны эх үүсвэртэй өрх 516 өрхөөр буюу 11.2 хувиар, телевизортой өрх 8.2 хувиар, автомашинтай өрх 14.4 хувиар, мотоциклтой өрх 18.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Трактортой өрх 3.5 дахин өссөн байна.

**Малчдын соёл ахуйн үзүүлэлт**


хүснэгт 2

	Өрхийн тоо							Малчин өрхийн тоонд эзлэх хувь						
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Цахилгааны эх үүсвэртэй	5317	4607	4654	4614	4559	4599	5115	103	88.3	85.9	82.4	78.3	77.3	83.7
Телевизортой	4142	4251	4267	4126	4318	4392	4754	80.1	81.5	78.8	75.6	74.2	73.8	77.8
Автомашинтай	2295	2412	2581	2449	2788	3078	3521	44.4	46.2	47.6	45.7	47.9	51.7	57.6
Мотоциклтой	2597	2705	2624	2638	2892	2898	3442	50.2	51.9	48.4	46.5	49.7	48.7	56.4
Трактортой	28	21	23	24	14	8	28	0.5	0.4	0.4	0.4	0.2	0.1	0.5

Эх сурвалж: 2013- 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

## Малчдын соёл ахуйн үзүүлэлт /2015-2019/

Зураг 2



## 2. МАЛ АЖ АХУЙН ТОО, БҮТЭЦ

2.1. Малын тоо.

2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн 15 сумын 59 багт 3.0 сая толгой мал тоолуулж 2018 оныхоос 401.8 мянган толгой малаар буюу 15.5 хувиар өссөн байна.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 157863 толгой, адуу 109526 толгой, үхэр 31653 толгой, хонь 718216 толгойд, ямаа 1983045 толгойд хүрсэн байна. Өмнөх оныхоос тэмээ 5582 толгойгоор буюу 3.7 хувиар, хонь 86804 толгойгоор 13.7 хувиар, адуу 12982 толгойгоор 13.4 хувиар, үхэр 4789 толгойгоор буюу 17.8 хувиар, ямаа 291706 толгойгоор буюу 17.2 хувиар тус тус өссөн байна.

хүснэгт 3

## Малын тоо


/төрлөөр/

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
									Хувь	Зөрүү
Бодоор*	376964	425661	474842	519869	584394	661517	668482	745557	111.5	77075
Толгойн тоо	1419253	1653264	1849043	2055765	2313963	2654388	2598440	3000303	115.5	401863
Тэмээ	97317	103120	112741	118584	130493	141232	152281	157863	103.7	5582
Адуу	50100	58164	66345	74170	85298	98651	96544	109526	113.4	12982
Үхэр	10762	13374	16085	18653	22149	26997	26864	31653	117.8	4789
Хонь	299816	350811	397600	447008	520905	613980	631412	718216	113.7	86804
Ямаа	961258	1127795	1256272	1397350	1555118	1773528	1691339	1983045	117.2	291706

\* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг 1 бод, тэмээг 1.5 бод, 6 хонь 8 ямааг тус бүр 1 бод гэж тооцов.  
Эх сурвалж: 2012-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зураг 3

## Малын өсөлтийн хувь /2019/



Зураг 3 - Нийт мал сүргийн өсөлтийн 66 хувийг ямаа, 24 хувийг хонь, 5 хувийг тэмээ, 4 хувийг адуу, үлдсэн 1 хувийг үхэр сүргийн өсөлт эзэлж байна.

## Малын тоо / сумдаар/


Сумын нэр	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Баяндалай	153575	168829	180270	190396	175787	206404	117.4
Баян-Овоо	96465	107805	124227	147595	142224	169701	119.3
Булган	131464	142671	165837	194503	205265	236711	115.3
Гурвантэс	140895	166228	181562	205078	187458	225294	120.2
Мандал-Овоо	116590	135139	157716	185166	209916	234072	111.5
Манлай	128835	133820	160576	188781	205418	220673	107.4
Номгон	216984	244795	262296	289869	262292	302862	115.5
Ноён	105200	116669	119638	126694	108306	132705	122.5
Сэврэй	130386	147538	156286	177238	172662	190480	110.3
Ханбогд	126467	133013	151446	172774	165527	190028	114.8
Ханхонгор	156261	174303	204635	242353	236686	280532	118.5
Хүрмэн	121208	137961	145908	159572	142790	169889	119.0
Цогт-Овоо	73695	85766	105999	131945	140197	154385	110.1
Цогтцэций	75156	82429	102660	130758	135026	159455	118.1
Даланзадгад	75862	78799	94907	111666	108886	127112	116.7
Дүн	1849043	2055765	2313963	2654388	2598440	3000303	115.5

Эх сурвалж: 2014-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нийт мал сүрэг өмнөх онтой харьцуулахад 15.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 4

## Малын тоо 2019 /сумдаар/



Аймгийн дундаж малын тоо 200020 толгой болж малын тоогоор 7 сум аймгийн дунджаас дээгүүр, 8 сум дунджаас доогуур байна.


## Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн хүчин зүйл

/мян.толгой/	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	хүснэгт 5	
									Хувь	Зөрүү
Бойжуулсан төл	393591	469222	450151	530744	540484	664257	399966	787730	196.9	387764
100 эхээс бойжуулсан төл	82	82	68.1	68.4	64	69	38	67	176.5	29
/ толгойгоор /										
Хээлтэгч малын тоо	575182	660840	776420	845476	963150	1066064	1174356	1192094	101.5	17738
Том малын зүй бус хорогдол	8815	9727	11128	17326	10089	11251	61994	8120	13.1	-53874
Хээл хаясан хээлтэгч	978	846	2241	2304	5370	2306	11240	2026	18.0	-9214
Сувайрсан хээлтэгч	79705	93158	183799	206988	278868	276346	593355	360404	60.7	-232951

Эх сурвалж: 2012-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малын өсөлтөнд нөлөөлдөг гол хүчин зүйл болох бойжсон төлийн тоо өмнөх оноос 387.7 мянган төлөөр, хээлтэгч малын тоо 1.5 хувиар өссөн, том малын зүй бусын хорогдол өмнөх оноос 53874 малаар буюу 7.6 дахин, сувайрсан хээлтэгч өмнөх оноос 1.6 дахин, хээл хаясан хээлтэгч 5.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 5



2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр бойжуулсан төл 787.7 мянгад хүрсэн нь өмнөх оны мал тооллогын дүнгээс 387.8 мянган төлөөр буюу 96.9 хувиар өссөн үзүүлэлттэй харагдаж байна.



Зураг 6

Хээлтэгч малын тоо нь 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1192.1 мянгад хүрсэн нь өмнөх мөн үеэс 17.7 мянгаар буюу 1.5 хувиар өссөн байна.

## Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

хүснэгт 6

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Тэмээ	4.8	4.9	8.3	7.2	6.9	6.2	6.1	5.8	5.6	5.3	5.9	5.3
Адуу	3.1	3.1	3.7	3.5	3.5	3.5	3.6	3.6	3.7	3.7	3.7	3.7
Үхэр	0.7	0.7	0.7	0.7	0.8	0.8	0.9	0.9	1	1.0	1.0	1.1
Хонь	20.8	21.4	21.1	21	21.1	21.2	21.5	21.7	22.5	23.1	24.3	23.9
Ямаа	70.5	69.9	66.2	67.5	67.7	68.2	67.9	68	67.2	66.8	65.1	66.1


Эх сурвалж: 2008-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл өмнөх оноос тэмээн сүрэг 0.6 хувиар, хонин сүрэг 0.4 хувиар буурч, үхэр сүрэг 0.1 хувиар, ямаан сүрэг 1.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бог малын 75.0 орчим хувийг хонь, 25.0 орчим хувийг ямаа эзэлж байх үед сүргийн бүтэц болон малын бэлчээр ашиглалтад зохистой байдаг. Бог малын дотор хонин сүргийн эзлэх хувь нь 27.2, ямаан сүрэг 72.8 хувийг тус тус эзэлж байгаа нь дээрх харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн алдагдаж байгааг илэрхийлж байна.

зураг 7

## Мал сүргийн бүтэц /2019/



Манай аймгийн хувьд нийт сүрэгт эзлэх ямааны хувь улсдаа хамгийн өндөр байгаа нь мал сүргийн бүтэцэд зохисгүй өөрчлөлт гарч байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Цаашид ямаан сүргийн тоо толгойн өсөлт үргэлжилвэл байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд муугаар нөлөөлөх нь тодорхой байна.

**2.2 . Хувийн / амины / малын тоо:**

2019 онд хувийн малын тоо 2988.3 мянган толгойд хүрч, нийт малын 99.6 хувийг эзэлж байна. Тэмээн сүргийн 99.4 хувь, адуун сүргийн 99.9 хувь, үхэр сүргийн 99.7 хувь, хонин сүргийн 99.5 хувь, ямаан сүргийн 99.6 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо өмнөх оноос 400.9 мянган толгой буюу 15.5 хувиар өссөн байна.

**Хувийн малтай өрх, малын тоо / төрлөөр/**

мян.толгой

хүснэгт 7

Он	Малтай өрхийн тоо мян.өрх	Бүгд	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2006	7.2	1140.3	70.7	42.1	8.6	249.2	769.7
2007	7.3	1383.8	74.6	46.3	10	293.4	959.5
2008	7.6	1666.1	80	53	12.3	347.2	1173.6
2009	7.6	1738.5	84.9	53.6	12.9	371.7	1215.3
2010	6.9	1002.2	83.2	37.6	7.5	210.4	663.6
2011	6.7	1216.7	87.5	43.4	8.7	255.4	821.8
2012	6.6	1409.2	96.6	50.1	10.7	296.8	954.9
2013	6.6	1642.1	102.4	58.2	13.3	347.4	1120.9
2014	6.7	1837.8	111.9	66.3	15.9	394.1	1249.4
2015	6.9	2043.4	117.8	74.2	18.5	443	1389.9
2016	7.1	2300.9	129.6	85.2	22	516.7	1547.4
2017	7.4	2642.4	140.2	98.5	26.9	610.3	1766.5
2018	7.5	2587.4	151.2	96.5	26.7	628.0	1685.0
2019	7.7	2988.3	156.9	109.5	31.5	714.6	1975.8

Эх сурвалж: 2003-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2019 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 66.1 хувийг ямаа, 23.9 хувийг хонь, 5.2 хувийг тэмээ, 3.7 хувийг адуу, 1.1 хувийг үхэр эзэлж байна.

**2.3 Малтай өрхийн малын бүлэглэлт.**

хүснэгт 8

	Малтай өрхийн тоо			Нийт өрхөд эзлэх хувь			Малын тоо /мян.толгой/		
	2017	2018	2019	2017	2018	2019	2017	2018	2019
Бүгд	7418	7496	7707	100	100	100	2643	2587	2988
10 хүртэл малтай	87	106	92	1.2	1.4	1.2	1	1	1
11-30 малтай	400	441	404	5.4	5.9	5.2	8	9	9
31-50 малтай	451	479	463	6.1	6.4	6.0	19	20	19
51-100 малтай	953	954	902	12.8	12.7	11.7	70	71	67
101-200 малтай	1207	1269	1254	16.3	16.9	16.3	177	187	185
201-500 малтай	2399	2393	2291	32.3	31.9	29.7	798	797	768
501-999 малтай	1419	1372	1637	19.1	18.3	21.2	961	923	1120
1000-1499 малтай	447	427	579	6.0	5.7	7.5	508	480	662
1500-2000 малтай	40	38	66	0.5	0.5	0.9	67	63	112
2001-ээс дээш малтай	15	17	19	0.2	0.2	0.2	33	37	45

Эх сурвалж: 2017-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт өрхийн 1.2 хувийг 10 хүртэл малтай өрх, 5.2 хувийг 11-30 малтай өрх, 6.0 хувийг 31-50 малтай өрх, 11.7 хувийг 51-100 малтай өрх, 16.3 хувийг 101-200 малтай өрх, 29.7 хувийг 201-500 малтай өрх, 21.2 хувийг 501-999 малтай өрх, 7.5 хувийг 1000-1499 малтай өрх, 0.9 хувийг 1500-2000 малтай өрх, үлдсэн 0.2 хувийг 2000 –с дээш малтай өрх эзэлж байна.

### Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

хүснэгт 9

	2016	2017	2018	2019	2019 он				
					Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Бүгд	321	356	345	388	20	14	4	93	256
10 хүртэл малтай	7	7	7	7	1	1	2	1	2
11-30 малтай	21	21	21	21	2	3	2	4	11
31-50 малтай	41	41	41	41	2	2	2	9	25
51-100 малтай	74	74	74	75	5	4	2	16	47
101-200 малтай	149	147	147	147	11	7	3	31	97
201-500 малтай	332	333	333	335	19	12	3	69	233
501-999 малтай	663	677	672	684	30	22	6	158	468
1000-1499 малтай	1128	1137	1123	1144	62	45	11	326	701
1500-2000 малтай	1651	1666	1662	1692	111	63	22	532	965
2001-ээс дээш малтай	2232	2215	2204	2381	146	85	8	823	1320

Эх сурвалж: 2016-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Аймгийн дунджаар нэг малтай өрхөд 388 мал оногдож байгаа нь 2018 оноос 43 толгой малаар өссөн байна. Малтай нэг өрхөд 20 тэмээ, 14 адуу, 4 үхэр, 93 хонь, 256 ямаа ногдож байна.

### 2.4 Хээлтэгч мал.

2019 онд 1192.1 мянган толгой хээлтэгч тоологдсон нь өмнөх оноос 1.5 хувиар буюу 17.7 мянган толгойгоор өссөн байна. Төрлөөр нь авч үзвэл ингэ 4.9 хувиар, гүү 16.1 хувиар, үнээ 20.4 хувиар, Эм хонь 4.5 хувиар өсч, Эм ямаа 0.6 хувиар буурсан байна.

### Хээлтэгч малын тоо

мян.толгой	2013	2014	2015	2016	2017	2018	2019	хүснэгт 10	
								2019/2018	
								хувь	зөрүү
Ингэ	35.4	37.5	39.7	44	47.6	51.9	54.4	104.9	2.5
Гүү	17	20.2	23.2	27.3	31.3	32.3	37.5	116.1	5.2
Үнээ	5.2	6.4	7.6	8.9	10.5	10.8	13.1	120.4	2.2
Эм хонь	145.2	172	191.4	220.5	253.1	286.0	298.8	104.5	12.8
Эм ямаа	458.1	540.3	583.6	662.4	723.6	793.3	788.3	99.4	-5.0
Дүн	660.8	776.4	845.5	963.2	1066.1	1174.4	1192.1	101.5	17.7


Эх сурвалж: 2013-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээлтэгч мал нь нийт малын 39.7 хувийг эзлэж байгаа бөгөөд тэмээн сүргийн 34.4 хувийг, адуун сүргийн 34.3 хувийг, үхэр сүргийн 41.3 хувийг, хонин сүргийн 39.8 хувийг, ямаан сүргийн 39.7 хувийг тус тус эзэлж байна.

**Хээлтэгч**

/төрлөөр ,хувь/


Зураг 8



Нийт хээлтэгчийн 4.0 хувийг ингэ, 3.0 хувийг гүү, 1.0 хувийг үнээ, эм хонь 24.0 хувь, эм ямаа 68.0 хувийг тус тус эзэлж байна.

**Хээлтэгч малын тоо /2003-2019 он/**

Зураг 9



Сүүлийн жилүүдэд хээлтэгч малын тоо тогтмол өсч байсан боловч 2010, 2011 онуудад буурч, 2012 оноос өсөх хандлагатай болсон байна.

**2.5 Төл бойжилт .**

2019 онд гарсан төлийн 99.7 хувь нь буюу 787.7 мянган төл бойжуулсан байна.. Бойжсон төлийн тоо 2018 оныхоос 387.7 мянган толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл гарсан ботгоны 99.6 хувь, унаганы 99.4 хувь, тугалны 99.7 хувь, хурганы 99.8 хувь, ишигний 99.6 хувийг бойжуулсан байна.

**Төл бойжилт**

хүснэгт 11

	2015	2016	2017	2018	2019	Үүнээс					2019/ 2018
						ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	540719	543751	670614	416276	790329	22557	18809	7150	221070	520743	189.9
Бойжсон	530741	540484	664257	399966	787730	22463	18705	7127	220569	518866	196.9
Хорогдсон	9978	3267	6357	16310	2599	94	104	23	501	1877	15.9
Бойжилтын хувь	98.2	99.4	99.1	96.1	99.7	99.6	99.4	99.7	99.8	99.6	103.7

Эх сурвалж: 2015-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2019 онд аймгийн дунджаар 100 эхээс 67 төл бойжуулсан байна. Өмнөх онтой харьцуулахад 100 эхээс бойжуулсан төл тэмээн сүрэг дээр буурсан бол бусад төрөл дээр өссөн үзүүлэлттэй байна.

**100 эхээс бойжуулсан төл**

хүснэгт 12

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Бүгд	75	8	78	82	82	68	68	64	69	38	67	176.3
Ингэ	50	45	45	59	45	55	44	54	46	49	43	88.4
Гүү	69	13	76	74	81	67	65	61	65	37	58	156.3
Үнээ	76	25	74	80	87	74	69	65	70	49	66	134.1
Эм хонь	85	11	87	89	90	80	77	79	81	55	77	140.2
Эм ямаа	73	5	44	83	82	65	67	60	66	30	65	218.0

Эх сурвалж: 2009-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

**2.6 Том малын зүй бусын хорогдол.**

2019 онд оны эхний малын 0.3 хувь нь буюу 8.2 мянган толгой мал хорогдсон нь 2018 оноос 53874 толгой малаар буюу 7.6 дахин буурсан байна. Нийт хорогдсон малын 78.9 хувийг ямаа сүрэг, 14.1 хувийг хонин сүрэг, 1.6 хувийг адуу сүрэг, 5.0 хувийг тэмээ сүрэг, 0.4 хувийг үхэр сүрэг тус тус эзэлж байна.

**Том малын зүй бус хорогдол**


хүснэгт 13

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018	Зөрүү
Бүгд	8815	9727	11128	17326	10089	11251	61994	8120	13.1	-53874
Тэмээ	288	364	354	481	244	190	546	410	75.1	-136
Адуу	215	196	402	582	228	211	1915	128	6.7	-1787
Үхэр	57	49	90	109	129	74	1096	30	2.7	-1066
Хонь	2179	2454	2406	2667	2310	2463	9533	1145	12.0	-8388
Ямаа	6076	6664	7876	13487	7178	8313	48904	6407	13.1	-42497

Эх сурвалж: 2012-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

## Зүй бус хорогдол /2008-2019 он/

Зураг 10

**2.7 Малын хээл хаялт, сувайралт.**

2018 онд оны эхний хээлтэгч малын 0.17 хувь нь буюу 2026 толгой хээлтэгч хээл хаяж, 30.7 хувьтай тэнцэх 360.4 мянган хээлтэгч сувайрсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 362.4 мянгад хүрч түүний 99.4 хувийг сувайрсан хээлтэгч, 0.6 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзлэж байна.

**Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо**

хүснэгт 14

	Хээл хаясан хээлтэгч						Сувайрсан хээлтэгч					
	2014	2015	2016	2017	2018	2019	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	2241	2304	5370	2306	11240	2026	183799	206988	278868	276346	593355	360404
Ингэ	3	79	13	9	67	13	535	294	496	580	1262	1735
Гүү	37	81	130	167	524	46	5484	6480	8584	9597	16990	13643
Үнээ	10	20	19	65	38	7	1457	1970	2551	2743	4945	3849
Эм хонь	372	319	309	178	901	333	27969	37856	42666	45901	106855	69844
Эм ямаа	1819	1805	4899	1887	9710	1627	148354	160388	224571	217525	463303	271333

Эх сурвалж: 2014-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээл хаясан хээлтэгч өмнөх онтой харьцуулахад 5.5 дахин, сувайрсан хээлтэгч 39.2 хувиар тус тус буурсан байна.

**Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь**


хүснэгт 15

	Хээл хаясан хээлтэгч						Сувайрсан хээлтэгч					
	2014	2015	2016	2017	2018	2019	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	0.3	0.3	0.6	0.2	0.4	0.2	23.7	24	33	28.7	22.4	30.7
Ингэ	0	0.2	0	0.0	0.0	0.0	1.4	1	1.2	1.3	0.9	3.3
Гүү	0.2	0.3	0.6	0.6	0.5	0.1	27.2	28	37	35.1	17.2	42.2
Үнээ	0.2	0.3	0.3	0.7	0.1	0.1	22.9	26	33.7	30.8	18.3	35.5
Эм хонь	0.2	0.2	0.2	0.1	0.1	0.1	16.3	20	22.3	20.8	17.4	24.4
Эм ямаа	0.3	0.3	0.8	0.3	0.5	0.2	27.5	27	38.5	32.8	26.1	34.2

Эх сурвалж: 2014-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

## Хээл хаялт, сувайралт

Зураг 11

**2.8. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо**

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь малын бүх төрөл дээр алдагдсан хэвээр байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна.

2019 онд 18.8 мянган толгой хээлтүүлэгч мал тоологдож 2018 оноос 12.5 хувь буюу 2094 толгойгоор өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгч мал таван төрөл дээр өссөн үзүүлэлттэй байна.

**Хээлтүүлэгч малын тоо**

хүснэгт 16

	Хээлтүүлэгч мал						
	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	12382	13375	14400	15971	17242	16771	18865
Буур	1027	1070	1111	1226	1275	1332	1384
Азарга	2594	2887	3248	3667	4044	4294	4666
Бух	251	293	357	429	459	485	544
Хуц	3111	3359	3628	4121	4430	4351	4882
Ухна	5399	5766	6056	6528	7034	6309	7389

Эх сурвалж: 2013-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа тэмээн сүргийн хувьд 20-25 байхад 39, адуун сүргийн хувьд 12-15 байхад 8, үхэр сүргийн хувьд 35-45 байхад 24 байна, харин бог малын хувьд нэг хээлтүүлэгчид ноогдох хээлтэгчийн тоо 25-30 байхад хонь 61, ямаанд 107 байгаа нь үржлийн норм ихээхэн алдагдаж байгааг илтгэж байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа өмнөх онтой харьцуулахад үхэр сүрэг 2 хээлтэгчээр нэмэгдсэн, хонин сүрэг 5 хээлтэгчээр, ямаан сүрэг 19 хээлтэгчээр тус тус ацхасагдсан байна.

**Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо**

хүснэгт 17

	Үржлийн норм	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Буур	20-25*	34	35	36	36	37	39	39
Азарга	12-15.*	7	7	7	7	8	8	8
Бух	35-45*	21	22	21	21	23	22	24
Хуц	25-30*	47	51	53	54	57	66	61
Ухна	25-30*	85	94	96	101	103	126	107

Эх сурвалж: 2013-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

\*-нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тоо.

**2.9 Малын хэрэглээний зарлага.**

2019 онд аймгийн хэмжээнд оны эхний малын 14.5 хувь буюу 377.7 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2018 оноос 16.1 мянган толгой малаар буурсан байна. Малтай нэг өрх дунджаар жилд 49 мал үүнээс 2.1 тэмээ, 0.7 адуу, 0.3 үхэр, 17.2 хонь, 28.6 ямааг хэрэглээндээ зориулж зарцуулсан байна. Аймгийн нийт өрхөөр тооцож үзэхэд нэг өрх дунджаар 18 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

**Малын хэрэглээний зарлага**

хүснэгт 18

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	184.2	189.1	225.4	243.2	306.7	272.2	312.6	393.9	377.7
Тэмээ	8.1	8.1	8.8	9.6	10.2	9.3	9.5	11.7	16.5
Адуу	2.9	3.2	4	2.8	4.8	2.8	4.3	11.9	5.6
Үхэр	1.1	1	1	1.1	1.7	1.3	1.3	4.2	2.3
Хонь	52.4	46.7	59.6	67.3	80.3	75.8	84.1	113.3	132.6
Ямаа	119.6	130.1	152	162.4	209.7	182.9	213.5	252.8	220.8

Эх сурвалж: 2011-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

**Оны эхний малд эзлэх хувь**

хүснэгт 19


	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	18.2	15.4	15.9	14.7	16.6	13.2	13.5	14.8	14.5
Тэмээ	9.7	9.2	9	9.3	9	7.8	7.2	8.3	10.8
Адуу	7.7	7.3	8	4.8	7.2	3.8	5.0	12.1	5.8
Үхэр	15.2	11.4	9.4	7.8	10.7	7	6.0	15.4	8.6
Хонь	24.6	18.1	19.9	19.1	20.2	17	16.1	18.5	21.0
Ямаа	17.9	15.7	15.8	14.4	16.7	13.1	13.7	14.3	13.1

Эх сурвалж: 2011-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт хэрэглээнд зарцуулсан малын 93.5 хувийг бог мал, 6.5 хувийг бод мал эзэлж байна.

## Малын хэрэглээний зарлага /төрлөөр/

Зураг 12



## Зах зээлд худалдаж борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо

хүснэгт 20

	Зах зээлд худалдан борлуулсан						Аж ахуйн дотоодод хэрэглэсэн					
	2014	2015	2016	2017	2018	2019	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	85173	95525	104851	143414	207020	294932	129339	141479	145882	180797	152718	166409
Тэмээ	5429	4753	3549	6145	7664	12943	3198	3289	2935	3911	4032	4115
Адуу	2942	3021	1148	5359	9242	10105	2314	2765	1432	3605	3748	3617
Үхэр	777	952	5294	1660	2920	3194	1029	1217	3424	1836	1993	1945
Хонь	23342	25950	29478	39878	60594	94741	37914	40100	42795	51783	48247	54600
Ямаа	52683	60849	65382	90372	126600	173949	84884	94108	95296	119662	94698	102132

Эх сурвалж: 2014-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2019 онд зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн нийт малын 63.9 хувийг зах зээлд борлуулж, 36.1 хувийг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрхөд дунджаар 38 толгой малыг зах зээлд борлуулж, 21 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

**2.10 Сүргийн бүтэц.**

2018 онд нийт сүргийн 15.4 хувь нь буюу 399.9 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 38.8 хувь буюу 1007.3 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 45.2 хувь буюу 1174.4 мянган толгой хээлтэгч, 0.6 хувь буюу 16.8 мянган толгой хээлтүүлэгч гэсэн бүтэцтэй байна.

## 2019 оны сүргийн бүтэц


хүснэгт 21

	Толгойгоор					Нийт сүрэгт эзлэх хувь				
	Бүгд	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч
Бүгд	3000303	787730	1001614	1192094	18865	100.0	26.3	33.4	39.7	0.6
Тэмээ	157863	22463	79638	54378	1384	100.0	14.2	50.4	34.4	0.9
Адуу	109526	18705	48608	37547	4666	100.0	17.1	44.4	34.3	4.3
Үхэр	31653	7127	10918	13064	544	100.0	22.5	34.5	41.3	1.7
Хонь	718216	220569	193972	298793	4882	100.0	30.7	27.0	41.6	0.7
Ямаа	1983045	518866	668478	788312	7389	100.0	26.2	33.7	39.8	0.4

Эх сурвалж: 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

## Сүргийн бүтэц нийт сүрэгт эзлэх хувь

Зураг 13



## 3. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

**3.1 Бэлчээрийн хүрэлцээ.**

Газрын албаны 2019 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээрийн талбай 10.1 сая га талбайд хүрч малын тоо хонин толгойд шилжүүлснээр 4.2 сая толгойд хүрсэн байна. 2019 онд 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 41.9 толгой мал ногдож байна.


## Бэлчээрийн хүрэлцээ

хүснэгт 23

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/ 2018
Бэлчээрийн талбай /мян.га/	11372.2	11372.2	11363.8	11358.7	11357.8	11072.3	10302.1	10137.2	10138.9	100.0
Хонин толгойд шилжүүлсэнээр 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоо	16	18	21	23	26	30	36.9	37	41.9	113.2

Эх сурвалж: 2011-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зураг 14



Манай аймгийн хувьд бэлчээрийн талбай их байгаа хэдий ч ус худгийн хүрэлцээ хангамж муу, мөн малчдын суурьшил ихтэй газруудад ашигт малтмалын болон хайгуулын лицензтэй ААНэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаагаас малын бэлчээрийн хүрэлцээ багасаж байна.

**3.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт.**

2019 онд аймгийн хэмжээгээр 7242.85 тонн хадлан, 17.6 тонн таримал тэжээл, 1191.73 тонн гар тэжээл, 29.8 тонн даршны ургамал, 2212.95 тонн хужир шүү, 451.9 тонн төмс, 12.6 тонн ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.


**Өөрийн хүчээр бэлтгэсэн хадлан нэр, төрлөөр**

хүснэгт 24

тонн

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Хадлан өвс	4909.7	4265.8	9625.9	5360	6844.2	5626.6	7625.9	7242.85	95.0
Таримал тэжээл	17.9	28.5	36.6	247.5	57.2	17.7	8.11	17.6	217.0
Даршны ургамал	37.5	16.4	14.5	13.2	827.5	49.1	32.1	29.8	92.8
Гар тэжээл	803.3	519.5	726.5	1838.5	2598.3	1009.9	983.7	1191.73	121.1
Хужир шүү	801.6	1329.6	2771.6	4734.1	6189.6	3888.8	3931.6	2212.95	56.3
Төмс ногооны хаягдал	83.6	46.7	81.8	20.5	16.9	38.9	17.1	12.6	73.7
Үр тарианы хаягдал	2	3.1	1.3	17	0	25.8	3.4	4	117.6
Сүрэл	6	0.06	0.5	10.5	10.1	14.1	2	2	100.0

Эх сурвалж: 2012-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

**Хадлан өвс**

Зураг 15

2019 онд аймгийн хэмжээгээр 7242.85 тонн хадлан хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад 5.0 хувиар буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

**3.3 Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж**

хүснэгт 25	тонн								
	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Бүгд	6659.69	6209.66	13258.7	12245.5	16543.8	10670.9	12603.91	10713.53	85.0
Хүчит	17.9	31.6	37.9	264.5	57.2	25.8	3.4	4	117.6
Шүүст	121.1	63.1	96.3	33.7	844.4	88	49.2	42.4	86.2
Бүдүүн	5719.1	4785.4	10352.9	7213.2	9452.6	6650.6	8611.6	8436.58	98.0
Бусад	801.6	1329.6	2771.6	4734.1	6189.6	3906.5	3939.71	2230.55	56.6
Хонин тодгойд шилжүүлсэн 1 мал ногдох тэжээл тэж.кг	3.3	3.3	4.9	4.2	7.1	2.8	3.6	2.5	69.4

Эх сурвалж: 2012-2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг тооцлоо. Тэжээл бүрээр тодорхой итгэлцүүр ашиглан тэжээлийн нэгжид шилжүүллээ.

## Дүгнэлт

2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн 15 сумын 59 багт 3.0 сая толгой мал тоолуулж 2018 оныхоос 401.8 мянган толгой малаар буюу 15.5 хувиар өссөн байна. Тооллогын дүнгээр тэмээний тоо 157863 толгой, адуу 109526 толгой, үхэр 31653 толгой, хонь 718216 толгойд, ямаа 1983045 толгойд хүрсэн байна. Өмнөх оныхоос тэмээ 5582 толгойгоор буюу 3.7 хувиар, хонь 86804 толгойгоор 13.7 хувиар, адуу 12982 толгойгоор 13.4 хувиар, үхэр 4789 толгойгоор буюу 17.8 хувиар, ямаа 291706 толгойгоор буюу 17.2 хувиар тус тус өссөн байна.

2019 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7707 малтай өрх, үүнээс 6108 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 36.5 хувийг малтай өрх эзэлж байна. 2019 онд мал аж ахуйн салбарт 9671 малчид ажиллаж байна. Нийт малчдын 43.8 хувь нь буюу 4237 эмэгтэйчүүд байна. Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 2.6 хувиар буюу 157 өрхөөр, малчдын тоо өмнөх оноос 0.8 хувиар буюу 78 малчнаар өссөн үзүүлэлт харагдаж байна. Нийт малчин өрхийн 30.0 хувийг 16-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд, 54.7 хувийг 35-аас 59 насны хүмүүс харин үлдсэн 15.3 хувийг тэтгэврийн өндөр настай хүмүүс эзэлж байна. Өмнөх онуудтай харьцуулахад 16-34 насны залуучууд мал аж ахуй эрхлэх нь буурч, 35-59 насны хүмүүс, тэтгэвэрийн насны хүмүүс мал аж ахуй эрхлэх нь ихэссэн үзүүлэлт харагдаж байна. Нэг малчин өрхөд 491 толгой мал оногдож байгаа нь өмнөх оноос 55 толгой малаар өссөн байна.

2019 оны мал тооллогын дүнгээр нийт малчин өрхийн 83.7 хувь буюу 5115 өрх цахилгааны эх үүсвэртэй, 77.8 хувь буюу 4754 өрх телевизортой, 57.6 хувь буюу 3521 өрх автомашинтай, 56.4 хувь буюу 3442 өрх мотоциклтой, 0.5 хувь буюу 28 өрх трактортой байна. Өмнөх онтой харьцуулахад цахилгааны эх үүсвэртэй өрх 516 өрхөөр буюу 11.2 хувиар, телевизортой өрх 8.2 хувиар, автомашинтай өрх 14.4 хувиар, мотоциклтой өрх 18.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Трактортой өрх 3.5 дахин өссөн байна. Өнөө үед мал аж ахуй эрхлэгчид малаа хариулахдаа адуу тэмээгээ унлага ачлагандаа ашиглах бус машин мотоциклийг түлхүү хэрэглэдэг болсон байна. Машин мотоцикль ашиглах нь малчдын цаг хугацаа, хүч хөдөлмөрийг маш их хөнгөвчилдөгтэй холбоотой юм.

Малын өсөлтөнд нөлөөлдөг гол хүчин зүйл болох бойжсон төлийн тоо өмнөх оноос 387.7 мянган төлөөр, хээлтэгч малын тоо 1.5 хувиар өссөн, том малын зүй бусын хорогдол өмнөх оноос 53874 малаар буюу 7.6 дахин, сувайрсан хээлтэгч өмнөх оноос 1.6 дахин, хээл хаясан хээлтэгч 5.5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Гарсан төлийн 99.7 хувь нь буюу 787.7 мянган төл бойжуулсан байна.. Бойжсон төлийн тоо 2018 оныхоос 387.7 мянган толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл гарсан ботгоны 99.6 хувь, унаганы 99.4 хувь, тугалны 99.7 хувь, хурганы 99.8 хувь, ишигний 99.6 хувийг бойжуулсан байна.

Оны эхний малын 0.3 хувь нь буюу 8.2 мянган толгой мал хорогдсон нь 2018 оноос 53874 толгой малаар буюу 7.6 дахин буурсан байна. Нийт хорогдсон малын 78.9

хувийг ямаа сүрэг, 14.1 хувийг хонин сүрэг, 1.6 хувийг адуу сүрэг, 5.0 хувийг тэмээ сүрэг, 0.4 хувийг үхэр сүрэг тус тус эзэлж байна.

Оны эхний хээлтэгч малын 0.17 хувь нь буюу 2026 толгой хээлтэгч хээл хаяж, 30.7 хувьтай тэнцэх 360.4 мянган хээлтэгч сувайрсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 362.4 мянгад хүрч түүний 99.4 хувийг сувайрсан хээлтэгч, 0.6 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзлэж байна.

18.8 мянган толгой хээлтүүлэгч мал тоологдож 2018 оноос 12.5 хувь буюу 2094 толгойгоор өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгч мал таван төрөл дээр өссөн үзүүлэлттэй байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа тэмээн сүргийн хувьд 20-25 байхад 39, адуун сүргийн хувьд 12-15 байхад 8, үхэр сүргийн хувьд 35-45 байхад 24 байна, харин бог малын хувьд нэг хээлтүүлэгчид ноогдох хээлтэгчийн тоо 25-30 байхад хонь 61, ямаанд 107 байгаа нь үржлийн норм ихээхэн алдагдаж байгааг илтгэж байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа өмнөх онтой харьцуулахад үхэр сүрэг 2 хээлтэгчээр нэмэгдсэн, хонин сүрэг 5 хээлтэгчээр, ямаан сүрэг 19 хээлтэгчээр тус тус ашхасагдсан байна.

Аймгийн хэмжээнд оны эхний малын 14.5 хувь буюу 377.7 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага 2018 оноос 16.1 мянган толгой малаар буурсан байна. Малтай нэг өрх дунджаар жилд 49 мал үүнээс 2.1 тэмээ, 0.7 адуу, 0.3 үхэр, 17.2 хонь, 28.6 ямааг хэрэглээндээ зориулж зарцуулсан байна. Аймгийн нийт өрхөөр тооцож үзэхэд нэг өрх дунджаар 18 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна. Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн нийт малын 63.9 хувийг зах зээлд борлуулж, 36.1 хувийг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрхөд дунджаар 38 толгой малыг зах зээлд борлуулж, 21 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Газрын албаны 2019 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээрийн талбай 10.1 сая га талбайд хүрч малын тоо хонин толгойд шилжүүлснээр 4.2 сая толгойд хүрсэн байна. 2019 онд 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 41.9 толгой мал ногдож байна.

Бэлчээрийн мал аж ахуйг цаашид хөгжүүлэхдээ бэлчээрийн даац, сүргийн бүтцээ зөв тохируулан, чанаржуулж өсгөх бодлогыг баримтлах хэрэгтэй байна.

Манай аймаг байгаль цаг агаар, газар нутгийн хувьд бусад аймгуудаас харьцангуй өвөрмөц онцлоготой бөгөөд ХАА-н салбар нь нийтдээ байгалиас шууд хамааралтай, эрчимжсэн аж ахуйн хөгжил сул байгаа зэрэг нь энэ салбарын цаашдын хөгжлийн талаар бодлого төлөвлөгөөтэй ажиллах зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм. Түүнчлэн ажилгүйдэл ядуурлын түвшинг байнга хэлбэлзүүлж байдаг энэ салбарт зах зээлийн өнөөгийн нийгэмд зохицсон бодлого хөтөлбөр гарган системтэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

2019 онд аймгийн хэмжээгээр 7242.85 тонн хадлан, 17.6 тонн таримал тэжээл, 1191.73 тонн гар тэжээл, 29.8 тонн даршны ургамал, 2212.95 тонн хужир шүү, 451.9 тонн төмс, 12.6 тонн ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.

## ТЭМДЭГЛЭЛ

**Боловсруулсан**

**мэргэжилтэн:**

С.Цэвэлмаа

**Хянасан**

**Статистикийн  
хэлтсийн дарга:**

С.Бямбабаатар

*Харилцах утас: 70533061, 70533439*

E-mail хаяг: [umnugobi\\_stat@yahoo.com](mailto:umnugobi_stat@yahoo.com)  
<http://www.umnugovi.nso.mn>

2020 оны 03 сарын 30